

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧИГ**

(Бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогчдод зориулсан гарын авлага)

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.....	3
1. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	5
1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	5
1.3. МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО.....	6
1.4. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ.....	7
1.5. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН САН.....	8
1.6. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	9
2. ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
2.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	16
2.2. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ.....	17
2.3. ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА.....	18
2.4. БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДАЛ.....	20
2.4.1. ХОЛБОО, ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ СИСТЕМИЙН БЭЛЭН БАЙДАЛ.....	20
2.4.2. ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮЧ ХЭРЭГСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ.....	21
2.4.3. ГАМШГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ.....	23
2.5. ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТ.....	24
3. ГАМШГИЙН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ	
3.1. ГАМШГИЙН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ.....	27
3.1.1. ГАМШГИЙН АЮУЛЫН ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ.....	27
3.1.2. ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	29
3.2. ГАМШГИЙН ХОХИРОЛ, ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ.....	29
3.3. БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛЭХ.....	30
3.4. ГАМШГИЙН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ.....	31
3.5. ХҮЧ ХЭРЭГСЭЛ ДАЙЧЛАН ГАРГАХ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ.....	32
4. ГАМШГИЙН ДАРААХ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ	
4.1. ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ ҮЕИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ.....	35
4.2. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ.....	36
4.2.1. ДОТООДЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ.....	36
4.2.2. ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ.....	36
4.3. КЛАСТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	37
4.4. СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (Жишээ).....	39
5. ХАВСРАЛТ	
5.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ, СТАНДАРТЫН ЖАГСААЛТ.....	41
5.2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	46

ӨМНӨХ ҮГ

Бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, орон нутгийн удирдлага болон оролцогч талууд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ашиглахад зориулж холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгээс түүвэрлэн энэхүү гарын авлагыг Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газар эмхтгэн боловсруулав.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичигт гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шат тус бүрд хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд оролцогч талуудын гүйцэтгэх чиг үүрэг, баримтлах эрх зүйн зохицуулалтын талаарх ойлголт, мдээллийг цогц байдлаар тусгах зарчмыг баримталсан болно.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын баримт бичгийг ашиглах албан тушаалтан, хувь хүн хэвлэж олшруулах, түүнчлэн холбогдох эрх зүйн зохицуулалтын жагсаалтад холбоосыг байршуулсанаар уг хууль тогтоомж, дүрэм журам, стандартын эх хувьтай танилцаж үйл ажиллагаандаа ашиглах боломжтой юм.

Цаашид энэхүү гарын авлагын бүтэц, агуулгыг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, зохицуулалт, оролцогч талуудын чиг үүрэг, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт орох үед болон илүү сайжруулах зорилгоор шинэчлэн боловсруулна.

1. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна.

1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Улсын Их Хурал, Засгийн газар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга зэрэг эрх бүхий субъектын баталсан хууль тогтоомж нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болно.



Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд:

- Хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх,
- Мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх,
- Шинжлэх ухаан, дэвшилтэт техник технологи, инновацид тулгуурласан байх,
- Өмчийн хэлбэрийг үл харгалзах,
- Иргэдийн оролцоонд тулгуурлах зарчмыг баримтална.

1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан дараах хэлбэрээр зохион байгуулна.

Гамшгийн өмнө:

- Гамшгийн эрсдэлийг үнэлэх,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх,
- Гамшгийн эрсдэлийг бууруулах,
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах,
- Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх,
- Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах,
- Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх,
- Гамшгийн орон зайн болон статистик мэдээллийг бүрдүүлэх,
- Орон зайн болон статистикийн мэдээллийн системээр дамжуулан олон нийт, иргэдийг үнэн, бодит мэдээллээр хангах.


Гамшгийн үед:

- Харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах,
- Голомтын бүсийг тогтоох,
- Эрэн хайх, аврах,
- Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх,
- Хор уршгийг арилгах,
- Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийх, сэргээн босгох төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

Гамшгийн дараа:

- Гамшгийн дараах хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх,
- Цацраг, химийн хордолт, бохирдлыг саармагжуулах, аюултай хог хаягдлыг устгах,
- Дэд бүтцийг сэргээн босгох,
- Нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах.

1.3. МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО



Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага

Улсын хэмжээнд:

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга,

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид:

- Тухайн шатны Засаг дарга,

Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлага удирдан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт

Улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөл ажиллана.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг


бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй.

Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий онцгой комисс ажиллана.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах бүсчилсэн тогтолцоо

Гамшгийн цар хүрээ ихэссэн тохиолдолд гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг нэгдсэн шуурхай удирдлага зохицуулалтаар хангах, гамшгийн голомтод хүч хэрэгслийг богино хугацаанд төвлөрүүлэх, шилжүүлэн байршуулах зорилгоор гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.



Онцгой байдлын байгууллагын бүсийн төв нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу ажиллана.

1.4. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана.

Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна¹.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- улсын болон орон нутгийн төсөв,
- орон нутгийн хөгжлийн сан,
- иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын хандив, тусламж,
- гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан олон улсын сан, буцалтгүй тусламж, зээл,
- Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр.

Засгийн газрын нөөц сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын нөөц сан нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц

эвдэрсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай даван туулахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, эрсдэлийг бууруулах, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах арга хэмжээг санхүүжүүлнэ.

Засаг даргын нөөц хөрөнгө

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаас гадна Сангийн сайдын тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-д зааснаар санхүүжүүлнэ.

Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 болон 2.1.2-т заасны дагуу байгалийн гамшигт үзэгдэл, ослын үед хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, таслан зогсоох, хохирлыг арилгах арга хэмжээг санхүүжүүлнэ.

¹ Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017

1.5. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН САН

Гамшгийн мэдээллийн санг:

- Гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл,
- Гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл,
- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ,
- Бусад мэдээллээр бүрдүүлэх бөгөөд эдгээр судалгаа, дүн мэдээ нь олон улсын болон дотоодын судалгаа шинжилгээний албан ёсны эх сурвалж болно.

Гамшгийн орон зайн мэдээллийн систем

Гамшгийн өмнө, үед, дараах үе шатанд

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын байршил, үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг системд зураглах,
- Гамшгийн төрөл тус бүрээр орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг оновчтой төлөвлөх,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэдээллийг олон нийттэй хуваалцах зорилго бүхий гамшгийн орон зайн мэдээллийн системийг ашиглана.

Гамшгийн орон зайн мэдээллийн систем – <https://map.nema.gov.mn/>

- Гамшгийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын систем - <http://vms.nema.gov.mn> – Гамшиг, аюулт үзэгдэл, осол, түргэн тусламжийн бүртгэлийг хийж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг удирдан чиглүүлнэ.
- Гамшгийн бүртгэл, хохирол хэрэгцээний дундын мэдээллийн систем - <http://data.nema.gov.mn>. Тохиолдсон гамшгийн үед үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, учирсан хохирол хэрэгцээний мэдээллийг бүрдүүлнэ.

- Ган, зудын гамшгийн эрсдэлийн мониторингийн систем - <http://prism-mng-test.surge.sh/>. Ган, зудын гамшгийн эрсдэлийн мониторингийн системээр дамжуулан ган, зудын эрсдэл, эмзэг байдал, өртөнгө, чадавх зэрэг үр дүнгийн мэдээллээр олон нийт, шийдвэр гаргагчдыг хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

1.6. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОРОЛЦОГЧ ТАЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөл</p>	<ul style="list-style-type: none"> • Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед холбогдох асуудлыг шуурхай хэлэлцэж, УИХ, ЗГ-т чиглэл, зөвлөмж өгөх.
<p>Улсын Их Хурал</p>	<ul style="list-style-type: none"> • Үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл тохиолдсон үед уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай хэлэлцэж, хууль, бусад шийдвэрийг гаргах, • Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг тодорхойлох, • Улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох; • Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийг тогтоох; • Орон нутгийнхаас бусад улсын нөөцийн зарцуулалтын тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх. • Газрын тосны стратегийн нөөцийг хадгалах хэмжээ, байршлыг тогтоох асуудлаар Засгийн газарт чиглэл өгч захиран зарцуулах эрх нээх.
<p>Засгийн газар</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах талаар дүрэм, журам батлах, • Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Улсын Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах, • Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх, • Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах, • УОК-ын саналын дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох, холбогдох хөрөнгийг шийдвэрлэх, • Улсын онцгой комиссын саналыг үндэслэн шаардлагатай тохиолдолд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хуульд заасан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг түр хориглох, • Улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, • Стратегийн нөөцийн бараа, материалын байршил, тоо хэмжээг тогтоох, • Гамшгийн нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, • Улсын нөөцөөс бараа, материалыг зориулалтын дагуу гаргах, нөхөн бүрдүүлэх шийдвэр гаргах, • Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, • Улсын нөөцийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, • Даатгалд хамрагдах бараа, материалын нэр төрөл, санхүүжилтийн хэмжээг батлах; • Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журмыг батлах, • Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журмыг батлах, • Орон нутгийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
<p>Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл</p>	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын холбогдох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх, • Гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмж гаргах, • Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл,

	<p>хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах,</p> <ul style="list-style-type: none"> • Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх, • Орон нутгийн зөвлөлийг бодлого, зөвлөмжөөр хангах.
<p>Улсын онцгой комисс</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих, • Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас тогтоосон чиглэлийн хүрээнд ГХтХ 10 дугаар зүйлийн 10.4 болон 10.7 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих, • Гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох, • Гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, албан даалгавар, тушаал гаргах, • Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын талаар болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Засгийн газарт танилцуулах, • Шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах, • Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах.
<p>Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан чиглүүлэх, • Гамшгийн нөөцийг зохих журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавих, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, салбар хоорондын харилцан ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг батлах, • Гамшгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад шуурхай мэдээлэх, • Олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх, • Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх, • Онцгой байдлын байгууллагыг хөгжүүлэх бодлого болон түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх, • Барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсвийн төслийг Засгийн газарт оруулж батлуулах, • Нөөцийн бараа, материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, байршил, нэр төрөл, тоо хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах, нөхөн бүрдүүлэх талаархи саналыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавих, • Захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээнд гамшгийн нөөцийн бараа, материалыг захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх, • Орон нутгийн нөөцийн тоо хэмжээ, нэр төрлийг тухайн шатны эрх бүхий албан тушаалтантай зөвшилцөн тогтоох.

**Онцгой байдлын
асуудал
эрхэлсэн төрийн
захиргааны
байгууллага**

- Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих,
- Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих,
- Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх,
- Орон нутгийн онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих,
- Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах,
- Шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж, гамшгийн цагийн байдлыг нэгтгэн дүгнэж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах,
- Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардал, нөхөн төлбөрийн талаар санал боловсруулан хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх,
- Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих,
- Гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх,
- Гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх,
- Гамшгийн судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах, ашиглах,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, стандарт боловсруулах,
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд нь хяналт тавих,
- Гамшгаас хамгаалах талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих,
- Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах,
- Гамшгаас хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын болон дотоодын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх,
- Олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг нөөцийн салбаруудаар дамжуулан хэрэгжүүлэх,
- Улсын нөөцийн салбаруудын бараа, материалын хөдөлгөөний талаархи мэдээ болон санхүүжилтийн тайланг улсын нөөцийн салбаруудаас авч нэгтгэн, улирлаар гаргаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах,
- Гэрээт хадгалагчтай гэрээ байгуулж, нөөцийн бараа, материал хадгалах үйл ажиллагаанд нь хяналт тавих,
- Улсын нөөцийн салбарт бараа, материал бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохион

<p>Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга</p>	<p>байгуулах.</p> <ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах, • Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг дайчлан гаргах, хуваарилах, оролцуулах, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг чиглүүлэх, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, стандартыг баталж мөрдүүлэх, • Гамшгаас хамгаалах бэлэн байдлын удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих, • Гамшиг болон аюулын нөхцөл байдлын талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шуурхай мэдээлэх, • Гамшгаас хамгаалах харилцан ажиллагааны төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран батлах, • Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, • Барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хангамжийн талаарх бодлогыг боловсруулж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах, шийдвэрлүүлэх, • Хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, • Онцгой байдлын байгууллагыг төлөөлж гадаад, дотоодын байгууллагатай харилцах, • Онцгой байдлын байгууллагыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, цуцлах шийдвэр гаргах, • Үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг зэвсэгт хүчний ерөнхий командлагчид шууд танилцуулан шийдвэрлүүлэх.
<p>Нутгийн өөрөө удирдах байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> • Аймаг, сум, нийслэл, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг баталж, гүйцэтгэлд хяналт тавих, • Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох, тайланг хэлэлцэх, чиглэл өгөх, • Гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг хуулийн дагуу батлах.
<p>Засаг дарга</p>	<ul style="list-style-type: none"> • Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх, • Нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах, • Гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах, • Хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах, • Нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах, • Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, • Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, • Гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах,

	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх, • Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах, • Гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, • Орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж, хяналт тавих, • Улсын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, • Орон нутгийн нөөцийг бүрдүүлэх талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал өгөх.
<p>Гамшгаас хамгаалах алба</p>	<ul style="list-style-type: none"> • Салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, • Салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх, хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах, • Салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, • Гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах, • Салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх, • Орон нутгийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах, • Гамшиг болон аюулт нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах, • Голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах, • Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, • Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, • Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан гаргах, • Хариуцсан салбарын хүрээнд холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг боловсруулж батлуулах,
<p>Хуулийн этгээд</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, • Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх, • Үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх, • Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, • Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах, • Гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшиг болон аюулын нөхцөл байдлын тухай мэдээг дээд шатны байгууллага болон онцгой байдлын байгууллагад цаг тухайд нь хүргэх, шаардлагатай баримт бичиг, бодит мэдээллээр хангах, • Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах.

<p>Төрийн бус байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд иргэний хяналт тавих, • Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль тогтоомж, зөвлөмж арга зүй боловсруулахад оролцох, • Гамшгаас хамгаалах судалгаа, сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн, сайн дурын хэсэг, бүлэг, нөхөрлөлийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх • Онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах.
<p>Сайн дурын хэсэг</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах, • Эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг биелүүлэх, • Гамшиг болон аюулын нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагад үнэн зөв, бодит, шуурхай мэдээлэл өгөх, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд аюулгүй байдлаа хангаж оролцох.
<p>Иргэн</p>	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх, • Гамшгаас хамгаалах сургалтад оролцох, • Өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах, • Гамшиг болон аюулаас урьдчилан сэргийлэх, аврах арга, техник, багаж хэрэгслийг эзэмших, зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх, • Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, • Гамшиг болон аюулын тухай мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай, үнэн зөв хүргэх, • Эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөн, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардал, учирсан хохирол, хуурамч дуудлага өгсний улмаас гарсан зардлыг нөхөн төлөх, • Хорио цээр болон хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичигтэй зорчих.
<p>МУЗН</p>	<ul style="list-style-type: none"> • Монголын улаан загалмай нийгэмлэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт хүч болон ажиллана.

2. ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлах бөгөөд гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, хяналтыг хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах төрөлтэй байна.

2.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Гамшгийн эрсдэл гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг²,

гамшгийн эрсдэлийн үнэлгээ гэж хүн ам, эд хөрөнгө, амьжиргааны хэрэгсэл, тэдгээрийн хамаардаг хүрээлэн буй орчинд заналхийлж эсвэл хохирол учруулж болзошгүй аюулд дүн шинжилгээ хийж, эмзэг байдал, хамгаалах чадавх зэргийг үнэлэн, эрсдэлийн мөн чанар, цар хүрээг тодорхойлох үйл явцыг хэлнэ.³

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ

Зорилго:

Гамшгийн эрсдэлийг тойм, суурь судалгаа байдлаар тодорхойлох.

Гүйцэтгэх этгээд:

- **Улсын болон стратегийн онц чухал объектын түвшинд** – Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачаас бүрдсэн ажлын хэсэг;
- **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд** – Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг;
- **Салбарын түвшинд** – Гамшгаас хамгаалах улсын алба, тухайн салбарын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ

Зорилго:

Гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мэргэжлийн түвшинд нарийвчлан тодорхойлох, болзошгүй хохирлын хэмжээг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөх.

Гүйцэтгэх этгээд:

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд.

Нарийвчилсан үнэлгээ хийх чиглэл:

- Уул уурхай;
- Дэд бүтэц;
- Хөдөө аж ахуй;
- Байгаль орчин, түүх соёлын дурсгалт газар;
- Үйлдвэр, үйлчилгээ;
- Эрүүл мэнд.

Үнэлгээ хийх хугацаа:

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хуулийн этгээд, стратегийн болон онц чухал объектын түвшинд **3** жил тутам, эсхүл нөхцөл байдлаас хамааран тухай бүр хийнэ.

Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар”-ыг баримтлан хийнэ.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээг гамшгийн төрөл тус бүрээр хийх бөгөөд эрсдэлийн үнэлгээ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндэслэл болно.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Галын аюулгүй байдлын тухай хууль. 2015;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 190. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам. 2020.11.25;
4. Шадар сайдын тушаал. Дугаар 68. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар. 2021.07.21;
5. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/255. Эрсдэлийн үнэлгээний тайланг үнэлэх шалгуур үзүүлэлт. 2021.11.22.

² Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017.

³ MNS6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт.

2.2. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, эрэн хайх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг иж бүрнээр хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээг хэлнэ⁴.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах, эрэн хайх, хор уршгийг арилгах, сэргээн босгох, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.

Зорилго:

Гамшигт тэсвэртэй хот суурин, хүрээлэн буй орчныг цогцлоох, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, эрэн хайх аврах, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах зорилготой.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах болон батлах:

- Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж Засгийн газар;
- Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг боловсруулах бөгөөд Засаг дарга;
- Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг албаны даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг боловсруулж тухайн албаны дарга;

- Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг боловсруулан тухайн байгууллагын дарга, захирал тус тус батална.

Төлөвлөгөө боловсруулахдаа холбогдох байгууллагаас гаргасан гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги, хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, заавар, зөвлөмжийн дагуу боловсруулна.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ



Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний салбар төлөвлөгөө болох гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө нь холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, оролцогч талуудын нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх зорилготой.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгаанд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулна.

⁴ MNS6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт.

**Ажлын тусгай горимд шилжих,
ажиллах төлөвлөгөө**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлага орон нутаг, байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгтэй нийцүүлэн ажлын тусгай горимоор ажиллах төлөвлөгөөг батлан мөрдөж ажиллах бөгөөд энэ нь тухайн орон нутаг, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ын дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан тухай бүр тодотгол хийж, хэрэгжилтийг ханган ажиллана.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Галын аюулгүй байдлын тухай хууль. 2015;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 416. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө. 2015.10.19;
4. Шадар сайдын тушаал. Дугаар 120. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар. 2018.12.07;
5. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/388. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар. 2019.12.12;
6. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/274. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам. 2018.09.03;
7. Шадар сайдын тушаал. Дугаар 31. Гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах нийтлэг заавар, загвар. 2023.05.09.

**2.3. ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ,
СУРТАЛЧИЛГАА**

Гамшгаас хамгаалах сургалт гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд улсын алба, засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг сургаж дадлагажуулах үйл ажиллагааг хэлнэ.⁵

Зорилго:

Гамшгаас хамгаалах ангиллын сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнийг дадлагажуулахад чиглэнэ.

□ **Оюутан сурагч, сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалт**

- Цэцэрлэг, ерөнхий боловсролын дунд сургуульд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн дагуу,
- Политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагсдад 36-54 цагийн агуулгаар,
- Их, дээд сургуульд “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” 1 кредит цагийн хичээлийг заавал судлах хичээлийн тоонд оруулж гамшгаас хамгаалах тухай мэдлэг ойлголтыг системтэй олгоно.

□ **Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт**

Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах улсын албаны удирдах албан тушаалтан, штабын бүрэлдэхүүний сургалт дадлагыг 2 жилд 1 удаа Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн ангийн сургалт дадлагыг жил бүр тухайн улсын алба, орон нутгийн онцгой байдлын байгууллага хамтран зохион байгуулна.

□ **Иргэд, олон нийтийн сургалт**

Баг, хорооны Засаг дарга иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулна. Мөн хэрэгжүүлж буй төсөл

⁵ MNS6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт.

хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулна.

□ **Иж бүрэн болон команд штабын сургууль**

Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төлөвлөгөө⁶-ний дагуу жилд 2-3 аймаг, дүүрэгт гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлагыг зохион байгуулна.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулахад Монголын улаан загалмай нийгэмлэг эрхлэх асуудлынхаа хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

□ **Нэгдсэн сургалт, дадлага**

- Жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Лхагва гарагт “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тэмдэглэх бөгөөд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх, таниулах ажлыг улс орон даяар,
- Жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16.00 цагт улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага сургалт хийж, бэлэн байдлыг хангаж ажиллана.

□ **Онцгой байдлын байгууллагын сургалт**

Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан, бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан бодлого, журмын дагуу Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулна.

Гамшгаас хамгаалах сурталчилгаа

Гамшгаас хамгаалах сурталчилгаа, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ, телевиз, сонин, радио, үүрэн

холбооны оператор компаниуд, байгууллагын болон мэдээллийн цахим хуудсууд, телевизийн шууд нэвтрүүлэг гэх мэт сувгаар хүргэнэ.

Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулна.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Засгийн газрын тогтоол. Дугаар 67. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай. 2017.03.07;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 339. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх журам. 2011.11.30;
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал. Дугаар А/181. Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр батлах тухай. 2018.04.06;
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал. Дугаар А/138. Гамшгаас хамгаалах мэдлэг олгох хичээлийн агуулга тогтоох тухай. 2017.09.01;
6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал. Дугаар А/103. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс хичээл оруулах тухай. 2017.08.03;
7. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/130. Ангиллын сургалтын хөтөлбөр батлах тухай. 2016.05.10;
8. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/323. Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар. 2016.05.10;
9. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/309. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай. 2016.05.10.
10. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/49. Онцгой байдлын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам. 2021.03.04.
11. <https://nema.gov.mn/>;
12. <http://ontsgoisur.gov.mn/>

2.4. БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДАЛ

⁶ <https://nema.gov.mn/n/111173>

Бэлэн байдал гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээ⁷-г ойлгоно.

Өдөр тутмын бэлэн байдлын үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;
- Харилцаа холбоо, зарлан мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах, арга ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах,
- Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлийн бэлэн байдлыг хангах;
- Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;
- Гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх;
- Гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах;
- Салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах.

2.4.1. ХОЛБОО, ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ СИСТЕМИЙН БЭЛЭН БАЙДАЛ

Гамшгаас хамгаалах холбоо хэрэгсэл гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж байгаа харилцаа холбооны хэрэгсэл ба сүлжээ⁸, Гамшгийн аюулын эрт зарлан мэдээллийн систем гэж эрсдэлийг ойлгох, зураглах, болзошгүй аюулыг хянаж шинжлэх, урьдчилан анхааруулах, иргэн, хуулийн этгээдэд зарлан мэдээллийг нэгдсэн удирдлагаар ойлгомжтой,

⁷ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017.

⁸ MNS6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт.

шуурхай хүргэх, өгөгдсөн мэдээллийн дагуу хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны цогц⁹-ыг хэлнэ.

Онцгой байдлын ерөнхий газар, түүний дэргэдэх анги, нэгжүүд, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Нийслэлийн онцгой байдлын газар, хэлтсүүд, бүсийн төв, 21 аймгийн Онцгой байдлын газар, түүний салбар, нэгжүүд холбоо, мэдээллийн технологийн бүх төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон суурин болон хөдөлгөөнт холбооны зангилаатай байна.

Дээрх байгууллага, нэгжүүдэд холбоо, зарлан мэдээллийн MNS6979:2022, MNS6412:2013, MNS6740:2018, MNS6980:2022 стандартын дагуу техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангана.

Хэрэгжүүлэх чиг үүрэг

- Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв – холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, програм хангамж, сүлжээний бэлэн байдлыг хангах,
- Гамшгаас хамгаалах улсын алба - салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах,
- Бүх шатны Засаг дарга - харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн бэлэн байдлыг хангах,
- Хуулийн этгээд-зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх,
- Иргэд - зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх чиг үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

⁹ ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/149. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам. 2017.06.12

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Засгийн газрын тогтоол. Дугаар 339. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх журам. 2011.11.30;
3. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/149. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам. 2017.06.12
4. MNS6979:2022 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системд тавих техникийн ерөнхий шаардлага;
5. MNS6740:2018 Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага;
6. MNS6412:2013 Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага;
7. MNS6980:2022 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа.

ХҮЧ ХЭРЭГСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, түүний объект, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал байна¹⁰.

Гамшгаас хамгаалах алба

Гамшгаас хамгаалах салбар дундын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус алба ажиллана. Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн анги

Мэргэжлийн анги нь болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүч хэрэгсэл мөн.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т заасныг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар, 33 дугаар зүйлийн 33.1.4, 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тус тус мэргэжлийн ангийг байгуулна. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн үйл ажиллагааг “Мэргэжлийн ангийн дүрэм”-ээр зохицуулна.

Сайн дурын хэсэг

2.4.2. ГАМШГААС ХАМГААЛАХ

¹⁰ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017.

Сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг ажиллаж болно. Сайн дурын хэсгийн ажилтныг “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”-ын дагуу бүртгэж Засаг даргын шийдвэрээр байгуулна.

Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг орон нутгийн засаг захиргааны санаачилгаар сайн дурын үндсэн дээр нэгдэж, объектын болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулагдана.

Хуулийн этгээд

Үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, мэргэжлийн ангийн зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Бэлэн байдлын үзлэг

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын даргын баталсан журмын дагуу зохион байгуулна.

Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн анги, хуулийн этгээдэд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг төлөвлөгөөт болон хяналтын хэлбэрээр зохион байгуулна.

Төлөвлөгөөт бэлэн байдлын үзлэгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт 4 жилд нэгээс доошгүй удаа, улсын албанд 2 жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь Онцгой байдлын байгууллагаас зохион байгуулж байгаа бэлэн байдлын үзлэг, гамшгаас хамгаалах команд штаб, иж бүрэн сургуулийн үед, мөн үүссэн

нөхцөл байдал нь ажлын хэвийн горимоор ажиллах боломжгүй болсон тохиолдолд ажлын тусгай горимд түр шилжин ажиллана.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Галын аюулгүй байдлын тухай хууль. 2015;
3. Улсын нөөцийн тухай хууль, 2007;
4. Засгийн газрын тогтоол. Дугаар 347. Гамшгаас хамгаалах улсын албаны нийтлэг журам. 2018.11.21;
5. Шадар сайдын тушаал. Дугаар 75. Мэргэжлийн ангийн дүрэм. 2017.08.17;
6. Шадар сайдын тушаал. Дугаар 24. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам. 2018.03.13
7. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/185. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар. 2016.06.24;
8. Шадар сайдын тушаал. Дугаар 38. Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам. 2019.05.10;
9. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/315. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг зохион байгуулах, үнэлэх журам. 2017.12.13;
10. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/274. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам. 2018.09.03.

2.4.3 ГАМШГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ

Улсын нөөц гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед энэ хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг, гамшгийн нөөц гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг¹¹ хэлнэ.

Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг Улсын нөөцийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулна.

Стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх ажлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

Стратегийн болон батлан хамгаалах материаллагаас бусад улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулна.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Улсын нөөцийн тухай хууль. 2007;
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль. 2005;
4. Засгийн газрын тогтоол. Дугаар 30. Стратегийн нөөцийн бараа материалын нэр төрөл батлах тухай. 2008.05.09;
5. Засгийн газрын тогтоол. Дугаар 199. Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдолт тооцох журам. 2008.05.28;
6. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/397. Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журам. 2019.12.13.

Улсын нөөц - нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед Улсын нөөцийн тухай хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материал

Стратегийн нөөц - нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр төрөл, тоо хэмжээг нь бууруулж үл болох нөөцийн бараа, материал

Батлан хамгаалах материаллаг нөөц-цэргийн материал хэрэгслийн хэрэгцээг тайван цагт болон дайны байдлын үед хангах зориулалт бүхий нөөц


Гамшгийн нөөц - гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материал

Орон нутгийн нөөц - тухайн шатны Засаг дарга, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах, аймаг, сум, нийслэл, дүүрэг, аж ахуйн нэгж байгууллагад байх нөөц

¹¹ Улсын нөөцийн тухай хууль, 2007.

2.5. ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТ

Хяналт шалгалт гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж буй үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг хэлнэ¹².



Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.

“Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм” болон “Гал түймрийн улсын хяналтын дүрэм”-ийн дагуу улсын хэмжээнд гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтыг гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэл

- гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийн биелэлт;
- гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт;

- төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, санхүүжилт, зарцуулалт;

- улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах сургалт, бэлтгэл, бэлэн байдал;

- гамшгаас хамгаалах зориулалттай хоргодох, түр амьдрах байр, цугларах талбай, нисдэг тэрэгний зогсоолын тоноглол, ашиглалтын байдал;

- гамшгаас хамгаалах зориулалттай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, хадгалалтын байдал;

- гамшгийн аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах бэлтгэл, бэлэн байдал;

- хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаа, хязгаарлалтын болон хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт;

- Засгийн газар, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын төв, орон нутаг дахь хуваарилалт, зарцуулалт;

- гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэлт, нөхөн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын байдал.

Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэл

- иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, санамж, сэрэмжлүүлэг өгч, галын аюулгүй байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх;

- Галын аюулгүй байдлын тухай, Барилгын тухай, Ойн тухай хууль, галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих;

¹² Төрийн хяналт, шалгалтын тухай хууль. 2003

- гал түймэртэй тэмцэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, төсвийн төлөвлөлт, тоног төхөөрөмж, гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн хангалт, ашиглалт, хадгалалтын байдалд хяналт тавих;

- барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах зураг төсөл техникийн нөхцөл, галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийсэн магадлалыг хянаж, дүгнэлт гаргах болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох;

- гал түймрийн аюулгүй байдлыг хангах талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтны хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, үнэлгээ өгөх, хэрэгжилтийг хангуулах;

- хот, суурины төлөвлөлт, барилга байгууламжийн байршлыг тогтоох, объектыг гал түймрийн аюулаас хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанд мэргэжлийн дүгнэлт гаргах;

- гал түймрийн судалгаа, тоо бүртгэл хөтөлж, гал түймэр гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнийг арилгахад чиглэсэн арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

- иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад объектын болон ой, хээрийн түймэр гарсан үед шуурхай мэдээлэх, унтраах бэлтгэл, гал түймрээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, учирч болох хохирлыг багасгахад чиглэсэн арга хэмжээг урьдчилан авсан эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжилтэд хяналт тавих;

- гал түймэр гарсан тохиолдолд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хойшлуулшгүй ажиллагаа явуулж, гал түймэр гарсан тухай акт тогтоох, тэмдэглэл хөтлөх;

- барилга байгууламж болон үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай

бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжид хийсэн гал түймрийн аюулын үнэлгээний чанарт хяналт тавих.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Галын аюулгүй байдлын тухай хууль. 2015;
3. Улсын нөөцийн тухай хууль. 2007;
4. Төрийн хяналт шалгалтын тухай хууль. 2003;
5. Зөрчлийн тухай хууль. 2017;
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017;
7. Засгийн газрын тогтоол. Дугаар 40. Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм. 2018.02.06;
8. Засгийн газрын тогтоол. Дугаар 48. Гал түймрийн улсын хяналтын дүрэм. 2016.01.18.

3. ГАМШГИЙН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Гамшгийн зэрэглэлээс хамааран хариу арга хэмжээг орон нутгийн, бүсийн, улсын хэмжээний түвшинд хэрэгжүүлнэ.

3.1. ГАМШГИЙН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу гамшгийн төрөл бүрээр хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах улсын алба, орон нутгийн түвшинд албаны болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Гамшиг, ослын үед хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг баримтална.

3.1.1. ГАМШГИЙН АЮУЛЫН ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл гэж хүн амд учирч болзошгүй гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг төвлөрсөн мэдээллийн хэрэгсэл, тусгай хэрэглээний холбоо, орон нутгийн болон олон нийтийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр нэн даруй хүргэхийг хэлнэ¹³.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах шийдвэрийг дор дурдсанаар гаргаж, нэн даруй зохион байгуулна:

- сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн болон үүсэж болзошгүй гамшгийн үед тухайн шатны гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр зарлан мэдээллийн хэрэгслээр;
- аймаг, нийслэл болон хэд хэдэн аймаг, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгийн үед гамшгаас

хамгаалах улсын алба, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн гарсан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр зарлан мэдээллийн хэрэгслээр;

- шаардлагатай тохиолдолд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр тус газрын Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч зарлан мэдээллийн хэрэгслээр гамшгийн аюулын тухай бүх нийтийн болон хэсэгчилсэн зарлан мэдээллийг хүргэж, шуурхай удирдан зохион байгуулна.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал гамшгийн тухай зарлан мэдээллийг хүлээн авмагц тухайн байгууллагад мөрдөх журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллага болон харьяа нэгжийнхээ хэмжээнд өөрийн зарлан мэдээллийн хэрэгслээр тодорхой давталттайгаар зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулна.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн ангилал, зэрэглэл

Гамшгийн аюулын зарлан мэдээллийг олон улсын стандартын байгууллагаас баталсан стандартыг үндэслэн 4 түвшинд харгалзах ангилал, зэрэглэлийн стандартын дагуу дамжуулна.



¹³ Засгийн газрын тогтоол. Дугаар 339. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах журам. 2011.11.30

Иргэдэд гамшгийн аюулын зарлан мэдээлэл хүргэх

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг бүх нийтэд “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах тухай” журам, “Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам”, ОБЕГ-ын даргын тушаалаар баталсан зааврын дагуу хүргэнэ.

Бие бүрэлдэхүүнд зарлан мэдээлэл хүргэх

ОБЕГ-ын бие бүрэлдэхүүнд “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам”-ын дагуу гамшгийн зарлан мэдээллийг хүргэнэ.

Бүсийн хэмжээнд

Бүсийн төвийн захирагчийн шийдвэрээр бүсийн зарлан мэдээлэх нэгж, аймгийн хэмжээнд Онцгой комиссын даргын шийдвэрээр Онцгой байдлын газар зарлан мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Орон нутгийн хэмжээнд

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан схем, төлөвлөгөөний дагуу зарлан мэдээллийг дамжуулна.

Эрх зүйн зохицуулалт:

1. Засгийн газрын тогтоол. Дугаар 339. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах журам. 2011.11.30;
2. Шадар сайдын тушаал. Дугаар 71. Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам. 2021.07.22;
3. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/68. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар. 2019.03.13;
4. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/304. Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам. 2020.12.28;
5. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар. А/149. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам. 2017.06.12.

6. MNS6980:2022. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системд тавих техникийн ерөнхий шаардлага;
7. MNS6980:2022. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа.

Гамшгийн үеийн мэдээ, мэдээлэл

Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.

Олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэг бүхий байгууллагууд гамшиг, ослын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааг олон нийтэд нэг сувгаар мэдээлэх түүнчлэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.13 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Шадар сайдын тушаал. Дугаар 92. Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам. 2022.12.09;
3. Шадар сайдын тушаал. Дугаар 28. Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдалд олон эх сурвалж ашиглан салбар хоорондын мэдээ, мэдээлэл солилцох журам. 2023.04.24;
4. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/49. Онцгой байдлын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам. 2021.03.04.

3.1.2. ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гамшгийн үед радио холбоог “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам”-аар хэрэгжүүлнэ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай “Чиглэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу холбоог зохион байгуулна.

Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага гүйцэтгэнэ.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Шадар сайдын тушаал. Дугаар 92. Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам. 2022.12.09;
3. ОБЕГ-ын даргын тушаал. Дугаар А/232. Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам. 2020.10.26.

3.2. ГАМШГИЙН ХОХИРОЛ, ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах арга хэмжээг гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үед болон хор уршгийг арилгах үе шатанд мөн хэрэгжүүлнэ.

Учирсан гамшиг, ослын улмаас үүсч болох эрсдэлийг тодорхойлох хүрээнд тохиолдож болзошгүй аюулын ямар эх үүсвэр байгаа болон тухайн аюулд хэн, юу өртөж болохыг олж тогтооход чиглэсэн өртөнгө, эмзэг байдлын үнэлгээ хийж эрсдэлийн магадлалыг бууруулах, зайлсхийхэд чиглэсэн хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.

Гамшгийн улмаас учирсан хохирол, хэрэгцээг Засгийн газраас баталсан “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам” -ын дагуу тодорхойлно.

Шуурхай үнэлгээ

Гамшгийн голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлгийн болон гал түймэр унтраах удирдагч, шаардлагатай тохиолдолд тухайн шатны Засаг дарга эсхүл орон нутгийн гамшгаас хамгаалах албаны даргын томилсон ажлын хэсэг 48 цагийн дотор хийж гүйцэтгэн тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад, шаардлагатай тохиолдолд тухайн шатны онцгой комисст хүргүүлнэ.

Гамшгийн хор уршгийг арилгах үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ

Орон нутгийн төрийн захиргааны байгууллага эсхүл тухайн шатны онцгой комиссоос томилсон, холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, салбарын шинжээчээс бүрдсэн шуурхай бүлэг 30 хоногийн дотор гүйцэтгэж, тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад, шаардлагатай тохиолдолд дээд шатны онцгой комисст хүргүүлнэ.

Үнэлгээний тайланд үндэслэн гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ,

аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардлагатай нөөцийг гаргах, дотоодын болон гадаадын хүмүүнлэгийн тусламжийг авах саналаа Улсын онцгой комисс Засгийн газарт гаргана.

Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээгээр тодорхойлох мэдээлэл:

- гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, дэд бүтэц, хүрээлэн буй орчинд учирсан шууд бодит хохирол;
- эрэн, хайх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардал;
- гамшгийн улмаас нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд доголдол гарснаас үүссэн шууд бус бодит хохирол;
- гамшигт нэрвэгдсэн хүн амын анхдагч хэрэгцээг хангахад шаардлагатай тусламж, үйлчилгээний мэдээлэл;
- эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд шаардагдах хүч хэрэгсэл, зардлын тооцоо;
- хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүү, техникийн мэдээлэл.

Эрх зүйн зохицуулалт:

1. Засгийн газрын тогтоол. Дугаар 1. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам. 2019.01.09;
2. Засгийн газрын тогтоол. Дугаар 190. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам. 2020.11.25;
3. Шадар сайдын тушаал. Дугаар 22. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар. 2020.03.12;
4. Шадар сайдын тушаал. Дугаар 68. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар. 2021.07.21;
5. Монгол Улсын стандарт. MNS ISO 31000:2020.

3.3. БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛЭХ

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт

- Бүрэн
- Хэсэгчилсэн байдлаар шат дараалан эсхүл шууд шилжүүлнэ.

Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан	
Улсын хэмжээнд эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт Улсын онцгой комиссын даргын саналыг үндэслэн	ЗАСГИЙН ГАЗАР
Хоёр буюу түүнээс дээш сум, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Онцгой комиссын даргын саналыг үндэслэн	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА
Сум, дүүргийн холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн	СУМ, ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА
Шаардлагатай тохиолдолд хариуцсан салбар, байгууллагыг	ГХУА-НЫ ДАРГА
Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан, гамшгаас хамгаалах улсын алба, аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтны сургалтын үед (түр)	ЗАСАГ ДАРГА

Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтан бэлэн байдлын зэргийг сунгах, бууруулах, цуцлах шийдвэрийг гаргана.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ГХтХ 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ОНЦ БАЙДАЛ ЗАРЛАХ

Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед онц байдал зарлана.

Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүргийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл эрхлэн гүйцэтгэнэ.

Онц байдал тогтоосон үед Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр онц байдал тогтоосон бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус хуулийн 10 дугаар зүйлд даасан онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Онц байдлын тухай хууль. 1995;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 327. Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт. 2018.10.27;
4. Засгийн газрын тогтоол. Дугаар 340. Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам. 2011.11.30.

3.4. ГАМШГИЙН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ

Аюулт үзэгдэл, ослын улмаас үүссэн гамшгийг тодорхойлох, гамшгийн зэрэглэлийг тогтооход Засгийн газрын тогтоолоор баталсан журмыг мөрдөнө.

Гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх, гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдлага зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламж хүсэх, үүссэн нөхцөл байдлын талаар нийтэд мэдээлэхэд гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлийг үндэслэл болгоно.

Тохиолдсон аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хамрах хүрээ, хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учруулсан хор уршгийг илэрхийлсэн шалгуур үзүүлэлтээр гамшгийн зэрэглэлийг тодорхойлно.

Гамшигт нэрвэгдсэн, амь насаа алдсан хүний тоо, хамарсан нутаг дэвсгэрийн хэмжээ, гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааны удирдлага зохицуулалт, оролцсон хүч хэрэгслийг харгалзан гамшгийг

- Орон нутгийн;
- Бүсийн;
- Улсын хэмжээний гэж зэрэглэл тогтоож шар, улбар шар, улаан өнгөөр тэмдэглэнэ.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Засгийн газрын тогтоол. Дугаар 327. Гамшгийн зэрэглэл тогтоох журам. 2018.10.27;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 327. Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт. 2018.10.27;
4. Засгийн газрын тогтоол. Дугаар 1. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам. 2019.01.09.

3.5. ХҮЧ ХЭРЭГСЭЛ ДАЙЧЛАН ГАРГАХ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ

Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг хэлнэ.¹⁴

Гамшиг, ослын үед дайчилгаа зарлах, нүүлгэн шилжүүлэлт хийх үйл ажиллагааг Засгийн газрын тогтоолоор баталсан “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг баримтлан гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

Гамшгийн аюулын цар хэмжээ, нөхцөл байдал, хамарсан хүрээ, учирсан хор уршгаас шалтгаалж шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулах бөгөөд дайчилгаа зарлах шийдвэр гаргах эрхтэй.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр, байгууллага, хуулийн этгээд түр цугларах аюулгүйн талбайтай байна.

Түр байр

Түр байрыг байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангах нь түр байранд байрлаж буй иргэдийн хэрэгцээг хангасан

¹⁴ Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017.

¹⁵ ОУШХБ. Түр байрны удирдлага. Гарын авлага. УБ, 2013

¹⁶ Засгийн газрын тогтоол. Дугаар 416. 2015.10.19

үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн хүмүүнлэгийн тусламжийн нэг хэлбэр юм¹⁵.

Түр байрыг байгуулах, удирдлага зохицуулалтаар хангахад хүмүүнлэгийн суурь стандарт зарчмууд, SPHERE стандарт, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, зааврыг мөрдөнө.

Хангалт

Гамшиг, ослын үед дараах байгууллагуудын удирдлагын шийдвэрээр хангалтыг зохион байгуулна¹⁶.




Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Засгийн газрын тогтоол. Дугаар 340. Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам. 2011.11.30;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 416. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө. 2015.10.19;
4. ОБЕГ-ын даргын тушаал. Түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байрны шаардлага батлах тухай. Дугаар А/305. 2020.12.28.

¹⁵

¹⁶

ГАМШИГ, ОСЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (ЗАГВАР)



5. ГАМШГИЙН ДАРААХ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ

Гамшиг, аюулын улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээ хамаарах бөгөөд нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах, дэд бүтцийг сэргээн босгох чиглэлтэй байна.

4.1. ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ ҮЕИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

Хойшлуулшгүй сэргээн босгох гэж гамшиг, аюулын улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг хэлнэ.¹⁷

Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээ

Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээг тухайн орон нутгийн Засаг дарга эсхүл холбогдох салбарын яамнаас томилсон ажлын хэсэг хийж гүйцэтгэнэ.

Энэ үнэлгээнд холбогдох мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагыг, шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн баг гүйцэтгэж болно.

Хойшлуулшгүй сэргээн босгох үеийн үнэлгээгээр хор уршгийг арилгах, сэргээн босгох, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах, тухайн төв, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусгах шаардлагатай дараах мэдээллийг нарийвчлан тодорхойлно.

- гамшигт өртсөн хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагт учирсан шууд бодит хохирол, гамшигт нэрвэгдэгсдийн хэрэгцээ,

- нэмэгдүүлэх, дайчлах нөөц,

-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл.

Хугацаа

Гамшгийн төрөл, үүссэн нөхцөл байдлаас хамааран энэ үе шатны үнэлгээг **2-12** сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Хохирол, хэрэгцээний үнэлгээнд дараах элементүүдийг авч үзнэ.

1. Дэд бүтцийн хохирол, хэрэгцээ,
2. Байгууллагуудын үзүүлдэг үйлчилгээний тасалдал, нөлөөлөлд өртсөн иргэдийн мэдээлэл,
3. Шинэ болон шинээр гарч ирж буй эрсдэлүүд: гамшгийн улмаас бий болсон, хэрэв шийдвэрлэхгүй бол гамшгийн нөхцөл байдал муудаж, сэргээн босгох үйл явцад

сөрөг үр дагавар учруулж болзошгүй эрсдэлийг үнэлж, тэдгээрийг арилгахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлох;

4. Гамшгаас урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ хэр үр дүнтэй байсныг үнэлэх, сэргээн босгох стратегийн дутагдалтай талыг тодорхойлох,
5. Илүү сайнаар сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Сэргээн босгоход шаардлагатай хэрэгцээний мэдээллийг тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллагын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан нэгжид хүргүүлнэ.

Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаа, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан сэргээн босгох үйл ажиллагааг Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төв /Шуурхай штаб/ удирдан зохион байгуулна.

Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Засгийн газрын тогтоол. Дугаар 416. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө. 2015.10.19;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 1. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам. 2019.01.09;
4. Шадар сайдын тушаал. Дугаар 22. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар. 2020.03.12.

¹⁷ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017

4.2. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Хүмүүнлэгийн тусламж гэж иргэн, байгууллага, хуулийн этгээдээс гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж сайн дурын үндсэн дээр өгч байгаа мөнгөн хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материал, ажил, үйлчилгээг хэлнэ¹⁸.

4.2.1. Дотоодын хүмүүнлэгийн тусламж, хандив

Болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах, сэргээн босгох, тэмцэхэд улс орны нийгэм, эдийн засгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учирсан тохиолдолд хүмүүнлэгийн тусламж хүсэх шийдвэрийг улсын хэмжээнд Улсын онцгой комисс, орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Онцгой комисс гаргана.

Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжаар ирүүлсэн бараа, материал, мөнгөн хөрөнгийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахад Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 133 дугаар тогтоолыг баримтална.

4.2.2. Олон улсын хүмүүнлэгийн тусламж

Гамшгийн хор уршиг, хохирол үндэсний эдийн засаг, нөөц боломж, чадавхаас давсан тохиолдолд олон улсаас хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг хүсэх уриалгыг Засгийн газар гадаад улс, олон улсын байгууллагад гаргана.

Олон улсаас авах хүмүүнлэгийн тусламжийн төрөл, хариуцах байгууллагыг Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэгжүүлнэ. Гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаатай холбогдуулан олон улсаас үзүүлж буй хүмүүнлэгийн

тусламжийг удирдлага, зохицуулалтаар хангах үйл ажиллагааг хүмүүнлэгийн баг хариуцан зохион байгуулна.

Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зогсоох

Улсын онцгой комиссын саналыг үндэслэн Засгийн газар тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг гаргана. Энэ шийдвэрийг тусламж үзүүлэгч талд 30 хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдэнэ.


Эрх зүйн зохицуулалт:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль. 2017;
2. Улсын нөөцийн тухай хууль. 2007;
3. Засгийн газрын тогтоол. Дугаар 416. Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө. 2015.10.19;
4. Засгийн газрын тогтоол. Дугаар 133. Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам. 2020.10.07;
5. Шадар сайдын тушаал. Дугаар 117. Хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам. 2018.11.30.

¹⁸ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017.

4.3. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН КЛАСТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улс дахь Хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах бүтэц




Сектор болон ахлах байгууллага

Шим тэжээл НҮБ-ын ХС	Ус ариутгал, ариун цэвэр НҮБ-ын ХС	Боловсрол НҮБ-ын ХС, ХИС	Боловсрол НҮБ-ын ХС, ХИС
Хүнсний аюулгүй байдал, ХАА НҮБ-ын ХХААБ	Эрүүл мэнд ДЭМБ	Оромж, орон сууц МУЗН (ОУХС)	
Ложистик НҮБ-ын ХС	Ложистик НҮБ-ын ХС	Онцгой байдлын үеийн харилцаа холбоо НҮБ-ын ХС	


Монгол Улс дахь Хүмүүнлэгийн баг

Монгол Улс дахь Хүмүүнлэгийн тусламжийн баг үндсэн ба өргөтгөсөн багаас бүрдэх бөгөөд өргөтгөсөн багийг НҮБ-ын Суурин зохицуулагч, ОБЕГ-ын даргын хамт ахлах ба дараах багуудаас бүрдэнэ.

Монгол Улс дахь Хүмүүнлэгийн тусламжийн багийн бүтэц



4.4. СЭРГЭЭН БОСГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ (жишээ)



- ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- Эрдэлийг үнэлэх,
 - Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
 - Олон нийтийг чадавхжуулах, барилга байгууламжийг хүчигтэх,
 - Хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах,
 - Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлын дадлага сургууль хийх,
 - Түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлэх,
 - -----

- БОГИНО ХУГАЦААНЫ СЭРГЭЭН БОСГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- **Хоргодох байр**
-Олон нийтэд яаралтай тусламж, хоргодох байр гэх мэт үйлчилгээг нэгдсэн байдлаар үзүүлэх,
-хүнс, ус, эм тарна, бусад тусламжийг үзүүлэх,
 - **Эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх**
 - **Хөг хаягдал**
- Цэг болон тээврийн маршрутыг тодорхой болгох,
 - **Бизнес, бусад үйл ажиллагаа**
- Бизнес, бусад төрлийн үйл ажиллагаа хэвийн явагдахад дэмжлэг үзүүлж түр хугацааны дэд бүтцийг бий болгох,

- **Эрдэл, эмзэг байдлыг үнэлэх, ойлгох,**
- -----

- ДУНД ХУГАЦААНЫ СЭРГЭЭН БОСГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- **Түр байр**
-Хүртгэмжтэй түр орон сууцны шийдлийг гаргах,
 - **Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх**
- Эрүүл мэндийн түр байгууламжаар дамжуулан тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх
 - **Хөг хаягдал/дэд бүтэц**
- Хөг хаягдалыг зайлуулах ажлыг эхлүүлэх,
- Дэд бүтцийг сэргээн засварлах ажлыг яаралтай төлөвлөх,
 - **Бизнес, бусад үйл ажиллагаа**
- Шаардлагатай тохиолдолд бизнесийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх,
- Бизнесийг сэргээх нэг цэгийн үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх,

- **Эрдэлийг бууруулах**
-Сэргээн босгох боломжуудын талаар олон нийтэд мэдээлэх
- -----

- УРТ ХУГАЦААНЫ СЭРГЭЭН БОСГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- **Орон сууц**
-Байнгын орон сууцны шийдлийг боловсруулах,
 - **Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх**
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг олон нийтэд хүргэх,
 - **Дэд бүтэц**
- Дэд бүтцийг ирээдүйн хот төлөвлөлт, хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулах
 - **Бизнес, бусад үйл ажиллагаа**
- Эдийн засгийг сэргээх стратегийг хэрэгжүүлэх,
- Бизнесийг сэргээхэд санхүүгийн тусламж үзүүлэх,

- **Эрдэлийг бууруулах**
- -----

5. ХАВСРАЛТ

5.1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, стандартын жагсаалт

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо	Холбоос
1.	Онц байдлын тухай	1995.11.14	https://legalinfo.mn/mn/detail/433
2.	Үндэсний аюулгүй байдлын тухай	2001.12.27	https://legalinfo.mn/mn/detail/18
3.	Гамшгаас хамгаалах тухай	2017.02.02	https://legalinfo.mn/mn/detail/12458
4.	Галын аюулгүй байдлын тухай	2015.07.02	https://legalinfo.mn/mn/detail/11222
5.	Улсын нөөцийн тухай	2007.07.05	https://legalinfo.mn/mn/detail/513
6.	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	2019.11.13	https://legalinfo.mn/mn/detail/14848
7.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай	2016.01.07	https://legalinfo.mn/mn/detail/11601
8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	2023.06.16	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760359992351

II. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

№	Эрх зүйн актын нэр	Дугаар	Батлагдсан огноо	Холбоос
1.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	48	2010.07.15	https://legalinfo.mn/mn/detail/6163
2.	Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай	85	2015.10.08	https://legalinfo.mn/mn/detail/11382
3.	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай	34	2016.04.14	https://legalinfo.mn/mn/detail/11891

III. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

№	Эрх зүйн актын нэр	Дугаар	Батлагдсан огноо	Холбоос
1.	Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай	11	2008.01.16	https://legalinfo.mn/mn/detail/3086/2/202299
2.	2008.01.16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	284	2010.11.10	https://legalinfo.mn/mn/detail?lawId=4341
3.	2008.01.16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	152	2017.05.30	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12686
4.	Тогтоолд өөрчлөлт оруулж журам батлах тухай	189	2020.11.25	https://legalinfo.mn/mn/detail/15766
5.	Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн	350	2022.09.22	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531424012421

	бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай			
6.	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн	38	2023.02.01	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758277718521
7.	Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам батлах тухай	347	2018.11.21	https://legalinfo.mn/mn/detail/13829
8.	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай	303	2015.07.20	https://legalinfo.mn/mn/detail/11284
9.	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги батлах тухай	355	2017.12.27	https://legalinfo.mn/mn/detail/13125
10.	Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	416	2015.10.19	https://legalinfo.mn/mn/detail/11827
11.	Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай	67	2017.03.07	https://legalinfo.mn/mn/detail/12495
12.	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх тухай	339	2011.11.30	https://legalinfo.mn/mn/detail/2728
13.	Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам батлах тухай	340	2011.11.30	https://legalinfo.mn/mn/detail/2731
14.	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам батлах тухай	190	2020.11.25	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389950471981
15.	Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам батлах тухай	1	2019.01.09	https://legalinfo.mn/mn/detail/13949
16.	Гамшгийн зэрэглэл тогтоох журам батлах тухай, Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт	327	2018.10.31	https://legalinfo.mn/mn/detail/13749
17.	Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам батлах тухай	133	2020.10.07	https://legalinfo.mn/mn/detail/15681
18.	Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм батлах тухай	40	2018.02.06	https://legalinfo.mn/mn/detail/13236
19.	Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам батлах тухай	201	2019.05.22	https://legalinfo.mn/mn/detail/14453

IV. СТАНДАРТ

№	Стандартын нэр	Дугаар	Холбоос
1.	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системд тавих техникийн ерөнхий шаардлага	MNS 6979:2022	https://nema.gov.mn/n/131844
2.	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа	MNS 6980:2022	https://nema.gov.mn/n/131847
3.	Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим,	MNS 6948:2021	https://fcy.gov.mn/website/news.aspx?id=3103

	салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага		
4.	Хот суурин газарт хийх эрэн хайх, аврах ажиллагаа	MNS 6455:2014	https://estandard.gov.mn/standard/reader/3806
5.	Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага	MNS 6740:2018	https://nema.gov.mn/n/49494
6.	Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага	MNS 6412:2013	https://estandard.gov.mn/standard/reader/3656
7.	Эрэн хайх, аврах ажиллагаа. Байгууллагын стандарт батлах тухай Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал.	A/410. ОББС 0001:2018 2018.12.04	https://nema.gov.mn/n/49491
8.	Тогтвортой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа, тэсвэртэй хотын үзүүлэлтүүд	MNS ISO 37123:2022	https://mcis.gov.mn/storage/uploads/process/202203/file_1648540583349142_161611878330710.pdf
96	Эрсдэлийн менежмент удирдамж	MNS ISO 31000:2020	https://estandard.gov.mn/uploads/ISO_31000-2020+++pdf

V. ШАДАР САЙДЫН ТУШААЛ

№	Эрх зүйн актын нэр	Дугаар	Батлагдсан огноо	Холбоос
1.	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай	50	2016.05.06	https://nema.gov.mn/n/16385
2.	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай	51	2021.05.18	https://nema.gov.mn/n/116021
3.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар батлах тухай	120	2018.12.07	https://nema.gov.mn/n/49519
4.	Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам	92	2022.12.09	https://nema.gov.mn/n/137067
5.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаа хийх заавар. 2018 оны 125 дугаар тушаалд нэмэлт оруулах тухай	100	2019.10.31	https://nema.gov.mn/n/93828
6.	Хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам	117	2018.11.30	
7.	Мэргэжлийн ангийн дүрэм батлах тухай	75	2017.08.17	https://legalinfo.mn/mn/detail/12831
8.	Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам батлах тухай	24	2018.03.13	https://nema.gov.mn/n/49588
10.	Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам	38	2019.05.10	https://nema.gov.mn/n/92317
11.	Онцгой байдлын байгууллагын бүс, бүсийн төвийн ажиллах журам	51	2019.06.14	https://nema.gov.mn/n/49591

12.	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар батлах тухай	22	2020.03.12	https://nema.gov.mn/n/99122
13.	Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын үед олон эх сурвалж ашиглан салбар хоорондын мэдээ, мэдээлэл солилцох журам	28	2023.04.24	https://nema.gov.mn/n/142820
14.	Гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах нийтлэг заавар, загвар	31	2023.05.09	https://nema.gov.mn/n/143449
15.	Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар	68	2021.07.21	https://nema.gov.mn/n/118120

VI. САЙДЫН ТУШААЛ

№	Эрх зүйн актын нэр	Дугаар	Батлагдсан огноо	Холбоос
1.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс хичээл оруулах тухай	A/103	2017.08.03	https://info.undp.org/docs/pdc/Documents/MNG/Decree%20A103%20by%20Education%20Minister%2020170803.pdf
2.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал. Гамшгаас хамгаалах мэдлэг олгох хичээлийн агуулга тогтоох тухай	A/138	2017.09.01	
3.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал. Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр батлах тухай.	A/181	2018.04.06	https://openjicareport.jica.go.jp/pdf/12353041_03.pdf
4.	Сангийн сайдын тушаал. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам.	61	2021.04.20	https://old.legalinfo.mn/annex/details/11831?lawid=16325

VII. ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

№	Эрх зүйн актын нэр	Дугаар	Батлагдсан огноо	Холбоос
1.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам	A/274	2018.09.03	https://legalinfo.mn/mn/detail/13652/2/208677
2.	Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн ажиллах журам	A/149	2017.06.12	https://nema.gov.mn/n/49582
3.	Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам	A/314	2017.12.13	https://nema.gov.mn/n/49619
4.	Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам	A/232	2020.10.26	https://nema.gov.mn/n/108062
5.	Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар	A/68	2019.03.13	https://nema.gov.mn/n/49528

6.	Түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байрны шаардлага батлах тухай	A/305	2020.12.28	https://nema.gov.mn/n/111084
7.	Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар батлах тухай	A/185	2016.06.24	https://nema.gov.mn/n/17700
8.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар батлах тухай. (Аймаг, нийслэл, сум, дүүрэг, гамшгаас хамгаалах алба, байгууллага, аж ахуйн нэгжийн)	A/388	2019.12.12	https://nema.gov.mn/n/92263
9.	Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам	A/339	2014.12.09	https://nema.gov.mn/n/49576
10.	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах журам	A/315	2017.12.13	https://nema.gov.mn/n/49616
11.	Цацрагийн ослын үед ажиллах аюулгүй ажиллагааны заавар	A/863	2013.11.26	https://nema.gov.mn/n/49697
12.	Тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам	A/468	2013.06.18	https://nema.gov.mn/n/148138
13.	Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам	286	2008.05.15	https://nema.gov.mn/n/148140
14.	Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүн газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах төлөвлөгөө	A/304	2020.12.28	
15.	Онцгой байдлын байгууллагын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам	A/49	2021.03.04	https://nema.gov.mn/n/113185
16.	Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар	A/323	2017.12.20	https://nema.gov.mn/n/35125
17.	Хээрийн эмнэлэг дэлгэх заавар	A/303	2020.12.28	https://nema.gov.mn/n/111078

5.2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГХТХ	Гамшгаас хамгаалах тухай хууль
ГАБТХ	Галын аюулгүй байдлын тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ЗГ	Засгийн газар
ГЭБҮЗ	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл
ХАБҮЗ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл
УОК	Улсын онцгой комисс
ОК	Онцгой комисс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ШШ	Шуурхай штаб
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НОБГ	Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газар
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
ЗД	Засаг дарга
НЗБ	Нутгийн захиргааны байгууллага
ГЭБОНЗ	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл
ГХУА	Гамшгаас хамгаалах улсын алба
ГХОНА	Гамшгаас хамгаалах орон нутгийн алба
ГХМА	Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги
СДХ	Сайн дурын хэсэг
МУЗН	Монголын улаан загалмайн нийгэмлэг
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ХЭ	Хуулийн этгээд
ИОН	Иргэд, олон нийт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НҮБ-ын ХХААБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
НҮБ-ын ХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан
ХИС	Хүүхдийг ивээх сан

